ГАЗРЫН БИРЖИЙН ХЭЛТСИЙН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Ш.МАНДАХЗУЛЫН
2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ, ҮР ДҮН,
МЭРГЭШЛИЙН ТҮВШИНГ ҮНЭЛЭХ ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС

Байгууллагын нэр: Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газар

Нэгжийн нэр: Газрын биржийн хэлтэс

**1. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээ | Гүйцэтгэлийн түвшин | Нийт (70 оноо) |
|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 |
| 1. | Нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт | 88,9% | 58 |

**2. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Арга хэмжээний биелэлтийн хувь | Төсвийн шууд захирагчийн өгсөн үнэлгээ (15 хүртэл оноогоор) |
|---|---|---|---|
| 1. | Арга хэмжээ 1. | 100% | 15 |
| 2. | Арга хэмжээ 2. | 100% | 15 |
| **Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний дундаж оноо** | | | 15 |

**3. Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ**

| Д/д | Үзүүлэлт | Төсвийн шууд захирагчийн өгсөн үнэлгээ (15 хүртэл оноогоор) |
|---|---|---|
| 1. | Хандлага, ёс зүй | 15 |
| 2. | Удирдан зохион байгуулах | 15 |
| 3. | Асуудал шийдвэрлэх | 15 |
| 4. | Манлайлах | 15 |
| 5. | Багаар ажиллах | 15 |
| 6. | Харилцаа | 15 |
| Ур чадварын үзүүлэлт (ажлын онцлогоос хамаарсан) | | |
| 7. | Мэргэжлийн ур чадвар 1. | |
| 8. | Мэргэжлийн ур чадвар 2. | |
| 9. | Мэргэжлийн ур чадвар 3. | |
| **Хандлага, ёс зүй, ур чадварын дундаж оноо** | | 15 |

**4. Гүйцэтгэлийн үнэлгээ**

| Д/д | Үнэлгээний үзүүлэлт | Үзүүлэлт тус бүрийн оноо |
|---|---|---|
| 1. | Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт<br>*(Нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт)* | 58 |
| 2. | Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт<br>*(Төсвийн шууд захирагчийн үнэлгээ )* | 15 |
| 3. | Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ<br>*(Төсвийн шууд захирагчийн үнэлгээ )* | 15 |
| 4. | Үнэлгээний оноонд орсон өөрчлөлт | |

| | | |
|---|---|---|
| | *(Аргачлалын 6  дугаар хэсэгт заасан холбогдох заалтыг бичих)* | |
| **Нийт оноо** =<br>( Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний оноо + Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний оноо + Хандлага, ёс зүй, ур чадварын оноо ) - Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу хассан оноо | | 88 |

***Үнэлгээ өгсөн:***

Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газрын дарга

***Төсвийн шууд захирагч***

............................ (А.Энхманлай)

2025 оны 06 дугаар сарын 18 -ны өдөр

***Үнэлгээтэй танилцаж, зөвшөөрсөн:***

Газрын биржийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч

***Нэгжийн дарга:***

............................ (Ш.Мандахзул)

2025 оны 06 дугаар сарын 18 -ны өдөр

# ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН ГАЗРЫН ГАЗРЫН БИРЖИЙН ХЭЛТСИЙН 2025 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХОЁРДУГААР УЛИРЛЫН ТАЙЛАН

## НЭГ. БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГТ ТУСГАГДСАН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/ | Гүйцэтгэл -ийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| **Стратегийн зорилго 1.9. Газрын биржийн үйл ажиллагааг боловсронгуй болгож, үйл ажиллагааг өргөжүүлэх** | | | | | | | |
| **1.9.1** | **Цахим үйл ажиллагаатай газрын биржийг Газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын эрхлэх асуудлын хүрээнд байгуулж, газар, үл хөдлөх хөрөнгө /ҮХХ/-ийн нэгдсэн системийг бий болгоно.** | **Үйл ажиллагаа** | **Цахим үйл ажиллагаатай Газрын бирж** | **Газрын биржийн цахим систем /www.mle.mn/-ийг улсын хэмжээнд нэвтрүүлсэн.** | **Цахим үйл ажиллагаатай газрын биржийг Газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын эрхлэх асуудлын хүрээнд байгуулж, газар, үл хөдлөх хөрөнгө /ҮХХ/-ийн нэгдсэн системийг хэрэглээнд нэвтрүүлсэн байна.** | | |
| 1.9.1.1 | Газрын биржийн цахим системийн 3.0 хувилбарыг хэрэглээнд нэвтрүүлж, хэвийн үйл ажиллагааг хангах | Үйл ажиллагаа | Систем хөгжүүлсэн байдал | Газрын биржийн цахим систем хэрэглээнд нэвтэрсэн | **Эхний хагас жилд:**<br>Газрын биржийн цахим системийн шинэчилсэн 3.0 хувилбарыг хэрэглээнд нэвтрүүлж, тус системд ажиллах албан хаагчдыг мэргэжил арга зүйгээр хангасан байна.<br>**Жилийн эцэст:**<br>Газрын биржийн цахим системийн шинэчилсэн 3.0 хувилбарт ажиллах мэргэжилтэн, албан хаагчдыг чадавхижуулж, хэвийн үйл ажиллагаар хангасан байна. | Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газрын даргын 2025 оны 01 дүгээр сарын 07-ны өдрийн А/03 дугаартай тушаалаар Газрын биржийн цахим системийн (www.mle.mn)-ийн шинэчилсэн 3.0 хувилбарыг улсын хэмжээнд хэрэглээнд нэвтрүүлсэн. Үг системийг өдөр тутмын үйл ажиллагаандаа ашиглах талаар 21 аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар, Нийслэлийн Газар зохион байгуулалтын албанд 2025 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн 2/83 дугаартай албан бичгээр чиглэл хүргүүлж, системийн хэвийн үйл | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | ажиллагааг хангаг ажиллаж байна.<br>Мөн тус системд ажиллах албан хаагчдыг мэргэжил арга зүйгээр хангах ажлыг шат дараатайгаар хэрэгжүүлж байгаа бөгөөд 21 аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын холбогдох мэргэжилтнүүд, сумын даамлуудад цахим сургалт зохион байгуулж, мэргэжил, арга зүйгээр хангаг ажиллаж байна. | |
| 1.9.1.2 | Газрын биржийн цахим системээр газар өмчлөх, эзэмших, ашиглах эрхийн дуудлага худалдаа, эзэмших, ашиглах эрхийн төсөл сонгон шалгаруулалт зохион байгуулах | Үйл ажиллагаа | Тухайн жилийн төлөвлөгөөнд тусгагдсан нэгж талбарын тоо | Газрын биржийн цахим системээр зохион байгуулах боломж бүрдсэн. | **Жилийн эцэст:**<br>Тухайн жилийн төлөвлөгөөнд дуудлага худалдаа, төсөл сонгон шалгаруулалтаар олгохоор төлөвлөсөн газарт зохион байгуулсан байна. | Газрын биржийн цахим систем /www.mle.mn/-ээр газар өмчлөх, эзэмших, ашиглах эрхийн дуудлага худалдаа, төсөл сонгон шалгаруулалт зохион байгуулах ажлын хүрээнд дараах ажлыг хийж гүйцэтгээд байна. Үүнд:<br>- 2025 оны эхний хагас жилийн байдлаар нийт 98 газар эзэмших, ашиглах эрхийн дуудлага худалдаа зохион байгуулагдсан. Нийт зохион байгуулагдсан дуудлага худалдааны 86 нь цахим хэлбэрээр, 10 нь танхимаар зохион байгуулагдсан. Дуудлага худалдаанд нийт 256 иргэн, хуулийн этгээд оролцож, 7 тэрбум төгрөгийг Улсын төсөвт төвлөрүүлээд байна.<br>- 2025 оны хагас жилийн байдлаар нийт 35 газрын газар эзэмших, ашиглах эрхийн төсөл сонгон шалгаруулалт зохион байгуулсан. Үүнээс 47 нь Засгийн газраас | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хэрэгжүүлж буй Хөдөөгийн сэргэлтийн хүрээнд өрнүүлж байгаа малчдын “Шинэ хоршоо хөдөлгөөн”-ийг хэрэгжүүлэхэд чиглэгдсэн газар эзэмших төсөл сонгон шалгаруулалт ээлж байна.<br>Мөн аймаг, нийслэлийн Газрын төлбөр, татвар, биржийн асуудал хариуцсан мэргэжилтнүүд, сумын Газрын даамлуудад дуудлага худалдаа, төсөл сонгон шалгаруулалтын зар мэдээг бүртгэх, нийтэд мэдээлэх, зохион байгуулах талаар, дуудлага худалдаа, төсөл сонгон шалгаруулалтад оролцож буй хэрэглэгчид (иргэн, хуулийн этгээд)-д тус системд бүртгүүлэх, үнийн санал өгөх, төсөл илгээхэд мэргэжил, арга зүйн зөвлөгөөг цаг тухай бүрт нь өгч байна. | |

## ХОЁР. ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, ХҮРТЭЭМЖИЙГ САЙЖРУУЛАХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/ | Гүйцэтгэл-ийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| **Стратегийн зорилго 1.10. Орчин үеийн техник, технологийг ашиглан газар, үл хөдлөх хөрөнгийн татвар, төлбөрийн нэгдсэн бүртгэл, мэдээллийн системийг хөгжүүлэх** | | | | | | | |
| 1.10.1 | **Дэвшилтэд технологид суурилсан гурван хэмжээст газар, үл хөдлөх хөрөнгийн системийг хөгжүүлнэ** | **Үйл ажиллагаа** | **Систем хөгжүүлсэн байдал** | **Газрын кадастрын мэдээллийн сангийн систем болон Газрын үнэлгээ, төлбөр, татварын цахим систем** | **Дэвшилтэд технологид суурилсан гурван хэмжээст газар, үл хөдлөх хөрөнгийн бүртгэл мэдээллийн нэгдсэн системийг нэвтрүүлсэн байна** | | |
| 1.10.1.1 | Газрын төлбөр өсгөж тооцох усны сан бүхий | Үйл ажиллагаа | Газрын төлбөрийг | Газрын төлбөр, татварын цахим | **Эхний хагас жилд:** | Нийслэлийн 9 дүүргийн хэмжээнд газрын төлбөр өсгөж | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | газрын хил, заагийг нийслэлийн ИТХ-ын 2024 оны 06 дугаар сарын 13-ны өдрийн “Нийслэл хотын усны сан бүхий газрын хамгаалалтын бүсийг шинэчлэн тогтоох тухай” 69 дүгээр тогтоолоор баталсан хил заагаар шинэчлэн, газрын төлбөрийг дахин тооцоолж, ногдуулалт үүсэх | | тооцож ногдуулсан байдал | систем хэрэглээнд нэвтэрсэн | Газрын төлбөр өсгөж тооцох усны сан бүхий газрын хил, заагийг нийслэлийн ИТХ-ын 2024 оны 06 дугаар сарын 13-ны өдрийн “Нийслэл хотын усны сан бүхий газрын хамгаалалтын бүсийг шинэчлэн тогтоох тухай” 69 дүгээр тогтоолоор баталсан хил заагаар шинэчилж, Газрын төлбөр, татварын цахим системд бүртгэлтэй нийслэлийн хэмжээний бүх хүчинтэй гэрээний төлбөрийн шинэчлэн тооцоолж, газрын төлбөрийн ногдуулалтыг үүсгэсэн байна. | тооцох усны сан бүхий газрын хил, заагийг нийслэлийн ИТХ-ын 2024 оны 06 дугаар сарын 13-ны өдрийн “Нийслэл хотын усны сан бүхий газрын хамгаалалтын бүсийг шинэчлэн тогтоох тухай” 69 дүгээр тогтоолоор баталсан хил заагаар шинэчлэн мэдээллийн санд бүртгэж баталгаажуулсан. Газрын төлбөр, татварын цахим системд бүртгэлтэй нийслэлийн хэмжээний усны сан бүхий газарт газар эзэмшиж, ашиглаж буй иргэн, хуулийн этгээдийн 26,960 хүчинтэй гэрээний газрын төлбөрийг шинэчлэн тооцоолж, газрын төлбөрийн ногдуулалтыг үүсгэсэн. | |
| 1.10.1.2 | Чөлөөт бүсийн газарт газар ашиглаж буй иргэн, хуулийн этгээдийн газрын төлбөрийг Чөлөөт бүсийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1.3-т заасан орлогыг төвлөрүүлэх боломжийг бүрдүүлэх | Үйл ажиллагаа | Систем хөгжүүлсэн байдал | Газрын төлбөр, татварын цахим систем хэрэглээнд нэвтэрсэн | **Эхний хагас жилд:**<br>Газрын төлбөр, татварын цахим системд нэмэлт хөгжүүлэлт хийх ажлын даалгаврыг боловсруулж, батлуулан гүйцэтгэгч шалгаруулах үйл ажиллагааг хууль, журмын дагуу зохион байгуулсан байна.<br>**Жилийн эцэст:**<br>Чөлөөт бүсийн аж ахуйн үйл ажиллагааны орлогод төвлөрүүлэх боломжийг бүрдүүлэх | Газрын төлбөр татварын цахим системийн нэмэлт хөгжүүлэлт хийх 2025 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн АД/2025-42 дугаар ажлын даалгаврыг боловсруулж батлуулсан. Тус ажлын даалгаварт Чөлөөт бүсийн газарт газар ашиглаж буй иргэн, хуулийн этгээдийн газрын төлбөрийг Чөлөөт бүсийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1.3-т заасан орлогыг төвлөрүүлэх боломжийг бүрдүүлэх хөгжүүлэлт хийх ажлыг нарийвчлан тусгаж шаардлагатай төсөв, зардлын тооцоог гаргасан. Уг ажлын гүйцэтгэгчийг шалгаруулах ажлыг хууль, журмын дагуу зохион байгуулж 2025 оны 04 дүгээр сарын 17-ны өдөр 2025/56 дугаартай зөвлөх | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | үйлчилгээний гэрээ байгуулсан.<br>Газрын төлбөр татварын цахим системийн нэмэлт хөгжүүлэлт хийх АД/2025-42 дугаартай ажлын даалгаварт тусгасан 14 нэгж ажлуудаас дараах ажлуудыг хийж гүйцэтгээд байна. Үүнд:<br>- Газрын удирдлагын нэгдсэн цахим системд Чөлөөт бүсийн нутаг дэвсгэрийг тусад нь кодолж системд оруулсан;<br>- Газар эзэмших, ашиглах өргөдлийн явц 7 буюу захирамж, шийдвэртэй холбоход хөрөнгийн бүртгэл автоматаар үүсгэх боломжтой болсон;<br>- Ногдуулалт, нэхэмжлэх олноор үүсгэхэд "Татвар төлөгчийн дугаар бүртгэгдээгүй байна" гэсэн мэдэгдлийг дэлгэрэнгүй харуулах, давхаргын нэгж талбар хэсэгт өргөдлийн дугаараар хайлт хийх, харах боломжийг бүрдүүлсэн;<br>- Чөлөөт бүсэд газар ашиглаж буй иргэн хуулийн этгээдийн газрын төлбөрийн хөнгөлөлт, чөлөөлөлт тооцох хэсгийг хөгжүүлсэн;<br>- Цуцлагдсан нэхэмжлэхийн тайлбарыг харуулж, газрын төлбөрийн нэхэмлэхээр хувааж төлсөн төлөлтийн огноо, түүхийг дэлэрэнгүй харуулдаг болсон;<br>- Чөлөөт бүсийн газарт зөвхөн Монгол Улсын иргэн, хуулийн этгээдэд газар | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | ашиглуулахаар хөгжүүлэлт хийсэн. | |
| 1.10.1.3 | Аймаг, нийслэлийн ИТХ-аар газрын төлбөрийн хувь, хэмжээ, итгэлцүүр, түүнийг хэрэглэх зааг хязгаарыг шинэчлэх бүрд Газрын төлбөр, татварын системд бүртгэж баталгаажуулан газрын төлбөрийг тооцоолох, ногдуулалтыг үүсгэх ажлыг зохион байгуулах | Үйл ажиллагаа | Тухай бүр | Газрын төлбөр, татварын системийг нэвтрүүлсэн. | **Эхний хагас жилд:** ИТХ-аар батлагдсан тогтоол, хувь хэмжээг системд баталгаажуулсан байна. | Увс аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2024 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн "Аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2022 оны 7/07 тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай" 18/12 тоот тогтоолыг Газрын төлбөр, татварын цахим системд бүртгэж баталгаажуулж, сум тус бүсийн хил зааг, төлбөр тооцох итгэлцүүрийн утгуудыг системд оруулах ажлыг зохион байгуулж шинэчилсэн хувь хэмжээгээр газрын төлбөрийг тооцож, ногдуулалт үүсгэн Татварын удирдлагын нэгдсэн системд илгээсэн. | 100 |
| 1.10.1.4 | Газрын төлбөр, татварын цахим системээр нийт нэгж талбарт төлбөр бодох, ногдуулалт хийж, нэхэмжлэх үүсгэх ажлыг зохион байгуулах, хяналт тавих | Үйл ажиллагаа | Нийт хүчинтэй гэрээний тоо | Газрын төлбөр, татварын системийг нэвтрүүлсэн. | **Эхний хагас жилд:** Хуульд заасан хугацаанд Татварын нэгдсэн системд бүх ногдуулалтыг илгээсэн байна. | Аймаг, нийслэлийн ИТХ-ын тогтоолоор шинэчлэн батлагдсан тогтоолын хувь хэмжээгээр газрын төлбөрийг тооцох боломжтой бүх нэгж талбарт газрын төлбөрийг бодуулж, 545,561 нэгж талбарт 163.2 тэрбум төгрөгийн ногдуулалт, 470,831 нэгж талбарт 153.2 тэрбум төгрөгийн нэхэмжлэх үүсгэн Татварын удирдлагын нэгдсэн цахим системд илгээсэн. Мөн аймаг, нийслэлээс Газрын кадастрын мэдээллийн санд бүртгэлтэй бүх нэгж талбарт төлбөр бодох, ногдуулалт хийж, нэхэмжлэх үүсгэх ажилд хяналт тавин ажилласан. | 100 |
| 1.10.1.5 | Газар, үл хөдлөх, эд хөрөнгийн албан татвар ногдуулах, нэхэмжлэх | Үйл ажиллагаа | Өмчилсөн нийт нэгж талбар | Газрын төлбөр, татварын системийг нэвтрүүлсэн. | **Эхний хагас жилд:** Хуульд заасан хугацаанд Татварын нэгдсэн | Улсын хэмжээнд газар, үл хөдлөх эд хөрөнгийн албан татварыг 397,839 нэгж талбарт | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | үүсгэх ажлыг зохион байгуулах, хяналт тавих | | | | системд бүх ногдуулалтыг илгээсэн байна. | 2 тэрбум 513 сая төгрөгийн ногдуулалт, 290,893 нэгж талбарт 1 тэрбум 1 сая төгрөгийн нэхэмжлэхийг үүсгэж, Татварын системд илгээсэн.<br>21 аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын газрын үнэлгээ, төлбөр, татвар хариуцсан мэргэжилтний газар, үл хөдлөх, эд хөрөнгийн албан татвар ногдуулах, нэхэмжлэх үүсгэх ажилд хяналт тавьж зарим алдаатай үүссэн ногдуулалт, нэхэмжлэхийг засварлаж, мэргэжил, арга зүйн зөвлөгөөгөөр хангаж ажилласан. | |
| **Стратегийн зорилт 1.11. Газрын үнэлгээний зах зээлийн үнэлгээ хийх аргачлалыг олон улсын жишигт нийтцүүлэн илүү боловсронгүй болгох** | | | | | | | |
| **1.11.1** | **Газрын зах зээлийн үнэ цэнийг тогтоох, олон улсын жишигт нийцүүлэн болосронгүй болгох** | **Үйл ажиллагаа** | **Засгийн газрын тогтоол** | **Засгийн газрын 2018 оны 181 дугаар тогтоол** | **Газрын зах зээлийн үнэлгээ хийх аргачлалыг олон улсын жишигт нийцүүлэн боловсронгуй болгож батлуулсан байна.** | | |
| 1.11.1.1 | Газрын үнэлгээний цахим системийн газрын нөхөх олговрын мэдээллийн санг бүрдүүлэх, нөхөх олговортойгоор газар чөлөөлсөн, солих буюу эргүүлэн авсан газрын нөхөн бүрдүүлэлт хийх, мэдээллийн сан хөтлөх | Үйл ажиллагаа | Систем хөгжүүлсэн байдал | Газрын үнэлгээний цахим систем хэрэглээнд нэвтэрсэн | **Эхний хагас жилд:**<br>Газрын үнэлгээний цахим системд нөхөх олговортойгоор чөлөөлсөн, солих буюу эргүүлэн авсан газрын мэдээллийн санг бүрдүүлэх ажлын арга зүйгээр хангаж, бүртгэл мэдээлэлд хяналт тавьж ажиллана.<br>**Жилийн эцэст:**<br>Газрын үнэлгээний цахим системд нөхөх олговортойгоор чөлөөлсөн, солих буюу эргүүлэн авсан газрын | Газрын үнэлгээний цахим системийн газрын нөхөх олговрын мэдээллийн санг бүрдүүлэх, нөхөх олговортойгоор газар чөлөөлсөн, солих буюу эргүүлэн авсан газрын нөхөн бүрдүүлэлт хийх, мэдээллийн сан хөтлөх талаар 21 аймаг, нийслэлд чиглэл өгч ажиллаж байгаа бөгөөд ажлыг шат дараатайгаар хэрэгжүүлж 21 аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын холбогдох мэргэжилтнүүд, сумын даамлуудад цахим сургалт | 80 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | мэдээллийн санг бүрдүүлэх ажлын арга зүйгээр хангаж, бүртгэл мэдээлэлд хяналт тавьж ажиллана. | хийж мэргэжил, арга зүйгээр хангаж ажиллаж байна. Мөн газрын үнэлгээний цахим системд нөхөх олговортойгоор газар чөлөөлсөн, солих буюу эргүүлэн авсан нийт 150 нэгж талбарын мэдээллийг бүртгэж баталгаажуулсан. | |
| 1.11.1.2 | Газрын дуудлага худалдааны үнэ төлсөн, нөхөн төлүүлсэн бүртгэлийн мэдээллийн сан үүсгэх, төлсөн мэдээллийг цахим системд бүртгэж баталгаажуулах, мэдээллийн сан хөтлөх | Үйл ажиллагаа | Систем хөгжүүлсэн байдал | Газрын үнэлгээний цахим болон кадастрын цахим систем хэрэглээнд нэвтэрсэн | **Эхний хагас жилд:** дуудлага худалдаагаар авсан болон дуудлага худалдааны үнийг нөхөн төлүүлсэн газрын мэдээллийн санг бүрдүүлэх ажлын арга зүйгээр хангаж, бүртгэл мэдээлэлд хяналт тавьж ажиллана.<br>**Жилийн эцэст:**<br>дуудлага худалдаагаар авсан болон дуудлага худалдааны үнийг нөхөн төлүүлсэн газрын мэдээллийн санг бүрдүүлэх ажлын арга зүйгээр хангаж, бүртгэл мэдээлэлд хяналт тавьж ажиллана. | 21 аймгийн газрын харилцаа барилга, хот байгуулалтын газар болон, нийслэл, дүүргийн газар зохион байгуулалтын албанд 2025 оны 02 дугаар сарын 14-ны өдөр 1/549 дугаартай албан бичгээр дуудлага худалдааны анхны үнэ төлсөн мэдээллийг нөхөж оруулах, мэдээллийн сан бүрдүүлэх, хөтлөх ажлыг зохион байгуулан ажиллах талаар чиглэл хүргүүлсэн. дуудлага худалдааны анхны үнэ тооцох, дуудлага худалдааны анхны үнэ төлсөн нэгж талбарын мэдээллийг нөхөн бүрдүүлэх, мэдээллийн сан хөтлөх гарын авлага боловсруулан 21 аймгийн ГХБХБГ болон Нийслэлийн ГЗБ-ын албанд 2025 оны 03 дугаар сарын 1/865 болон 1/800 дугаартай албан бичгүүдээр хүргүүлсэн. мөн 21 аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын холбогдох мэргэжилтнүүд, сумын даамлуудад цахим сургалт хийж мэргэжил, арга зүйгээр хангаж ажиллаж байна. Мөн 2157 нэгж талбарын дуудлага худалдааны анхны үнийг бодуулж, дуудлага худалдааны анхны үнэ төлсөн 132 нэгж | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | талбарын мэдээллийг нөхөн бүрдүүлсэн. | |
| 1.11.1.3 | Үл хөдлөх эд хөрөнгө зуучлагч байгууллагаас газар, үл хөдлөх хөрөнгийн үнийн мэдээлэл, Газар, үл хөдлөх хөрөнгийн барьцааны болон нөхөн олговрын үнийн мэдээлэл, зах зээлийн санал болгосон буюу зарлан мэдээлсэн үнийн мэдээллийг тус тус цуглуулах | Урсгал төсөв | 5000-8000 газар, үл хөдлөх хөрөнгийн зах зээлийн үнэ | Кадастрын мэдээллийн нэгдсэн системээр зохион байгуулах боломж бүрдсэн. | **Эхний хагас жилд:** Газрын биржийн цахим системд 1500-2500 газар, үл хөдлөх хөрөнгийн үнийн мэдээллийг цуглуулж, дүн шинжилгээ хийсэн байна.<br>**Жилийн эцэст:** Газрын биржийн цахим системд 5000-8000 газар, үл хөдлөх хөрөнгийн үнийн мэдээллийг цуглуулж, дүн шинжилгээ хийсэн байна. | 2025 оны эхний хагас жилийн байдлаар Газрын биржийн цахим системд нийт 110,199 газар, үл хөдлөх хөрөнгийн зах зээлийн үнийг бүртгэсэн бөгөөд үүнээс тухайн онд нийт 2,312 газар, үл хөдлөх хөрөнгийн зах зээлийн үнийн мэдээг нэмж бүртгэсэн.<br>Тухайн онд нэмж бүртгэсэн газар, үл хөдлөх хөрөнгийн зах зээлийн үнийн мэдээнээс 2,004 худалдагдсан, санал болгосон болон гэрээний үнийн мэдээ, 308 үнэлэгдсэн, барьцаа болон нөхөн олговрын үнийн мэдээлэл тус тус ээлж байна. Нийт цуглуулсан үнийн мэдээг зориулалтаар ангилахад гэр бүлийн хэрэгцээний газар 1707, худалдаа үйлчилгээний газар 188, хөдөө аж ахуйн газрын 109 тус тус бүртгэсэн байна.<br>Мөн тухайн онд бүртгэсэн үнийн мэдээнээс үл хөдлөх хөрөнгөгүй 1871, үл хөдлөх хөрөнгөтэй 133 газар, үл хөдлөх хөрөнгийн зах зээлийн үнийн мэдээ бүртгэгдсэн бөгөөд нийт 280.2 га газар эдийн засгийн эргэлтэд орсон байна. | 100 |
| 1.11.1.4 | Зах зээлийн үнийн мэдээг газрын үнэлгээний системд оруулж дүн шинжилгээ хийх, масс үнэлгээ хийх | Үйл ажиллагаа | 5000-8000 газар, үл хөдлөх хөрөнгийн зах зээлийн үнэ | Газрын үнэлгээний системийг нэвтрүүлсэн. | **Эхний хагас жилд:** Газрын биржийн цахим системд бүртгэгдсэн 1500-2500 газар, үл хөдлөх хөрөнгийн үнийн мэдээллийг үнэлгээний цахим системд оруулж | 2025 оны нэгдүгээр улиралд Газрын биржийн цахим системд бүртгэсэн 2,312 газар, үл хөдлөх хөрөнгийн зах зээлийн үнийн мэдээг Газрын үнэлгээний цахим системд оруулж Газрын үнэлгээний цахим системд өссөн дүнгээр | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | дүн шинжилгээ хийсэн байна.<br>**Жилийн эцэст:**<br>Газрын биржийн цахим системд бүртгэгдсэн 5000-8000 газар, үл хөдлөх хөрөнгийн үнийн мэдээллийг үнэлгээний цахим системд оруулж дүн шинжилгээ хийсэн байна. | бүртгэгдсэн 39,795 нэгж талбарын зах зээлийн үнийн мэдээг ашиглан 2025 онд инженерийн болон хүрээлэн буй орчин, нийгмийн дэд бүтцийн 10182 үнэд нөлөөлөх хүчин зүйлсийн утгыг ашиглан хот тосгон бусад суурин газрын масс үнэлгээг нийт 350000 нэгж талбарт уншуулан дүн шинжилгээ хийсэн. | |
| 1.11.1.5 | Нийслэлийн хоёр дүүргийг сонгон Газрын биржийн цахим системийг үйл ажиллагаандаа хэрхэн хэрэглэж буй байдалтай танилцаж, хяналт тавих, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх | Үйл ажиллагаа | Дүүрэгт ажилласан ажлын үр дүнг танилцуулсан тайлан. | Газрын биржийн цахим систем хэрэглээнд нэвтэрсэн | **Эхний хагас жилд:**<br>Сонгосон дүүргийн газрын албанд ажиллаж газрын биржийн цахим системийг хэрхэн үйл ажиллагаандаа ашиглаж буйтай танилцаж, гарсан үр дүнг байгууллагын удирдлагад танилцуулан. мэргэжил, арга зүйн зөвлөмж хүргүүлсэн байна. | Нийслэлийн Хан-Уул, Налайх дүүргийг сонгон Газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд дуудлага худалдаа, төсөл сонгон шалгаруулалтаар олгохоор төлөвлөгдсөн, иргэн, хуулийн этгээдэд газар олгосон талаар холбогдох судалгааны ажил хийж гүйцэтгэсэн.<br>Судалгаагаар Хан-Уул, Налайх дүүргийн хэмжээнд 2020-2024 онд гэр бүлийн хэрэгцээнээс бусад зориулалтаар Газрын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.2-т заасныг зөрчиж олгосон байх магадлалтай нийт 507 нэгж талбарын хувийн хэрэг болон холбогдох бусад мэдээллийг татаж дүгнэлт гаргах шаардлагатай байгаа бөгөөд гарсан үр дүнг байгууллагын удирдлагад танилцуулан, мэргэжил, арга зүйн зөвлөмж хүргүүлнэ. | 80 |

## ГУРАВ. ХУУЛИАР ТУСГАЙЛАН ОЛГОСОН ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/ | Гүйцэтгэл -ийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|

| Стратеги төлөвлөгөөний зорилго 3.7. Газрын харилцааны салбарын хяналт шалгалтын эрх зүйн орчныг сайжруулах, нэгдсэн удирдлагаар хангах | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| **3.7.2** | **Салбарын хууль тогтоомж шинэчлэн батлагдахтай холбогдуулан шаардлагатай эрх зүйн бусад актыг шинэчлэн боловсруулах, батлуулах** | **Үйл ажиллагаа** | **нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл** | **Газрын төлбөрийн тухай хууль /1997онд баталагдсан/** | **Газрын тухай хууль, Геодези, зураг зүйн тухай хууль, Газрын төлбөрийн тухай хууль, Кадастрын зураглал ба газрын кадастрын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг боловсруулж, холбогдох байнгын хороо, УИХ-аар хэлэлцүүлэхэд шаардлагатай мэдээ, мэдээллээр хангаж, хуулийн төслүүдийг батлуулахад холбогдох байгууллагуудтай хамтран ажилласан байна.** | | |
| 3.7.2.1 | Газрын төлбөрийн тухай хуулийг шинэчлэн боловсруулах ажлыг зохион байгуулах, хамтран ажиллах | Үйл ажиллагаа | 1 хуулийн төсөл | Газрын төлбөрийн тухай хууль /1997онд баталагдсан/ | **Эхний хагас жилд:**<br>Хуулийн төслийг төрийн байгууллага болон олон нийтэд танилцуулан, хэлэлцүүлэг хийж, санал дүгнэлт хүргүүлэх.<br>**Жилийн эцэст:**<br>Хуулийн төслийг төрийн байгууллага болон олон нийтэд танилцуулан, хэлэлцүүлэг хийж, санал дүгнэлт хүргүүлэх. | Газрын төлбөрийн тухай хуулийг шинэчлэн боловсруулах ажлын хүрээнд хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Газрын төлбөрийн тухай хуулийн зүйл, хэсэг, заалт нэг бүрийн хэрэгжилт, үр дүнгийн талаар тайлбар судалгааг гарган хуулийн төсөл боловсруулах багийн гишүүдэд хүргүүлж, хамтран ажиллаж байна.<br>Мөн Газрын төлбөрийн тухай хуулийн үзэл баримтлалд холбогдох санал боловсруулж, Газрын төлбөрийн тухай хуулийн шинэчилэн найруулгын төслийг боловсруулах хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлалыг хийж хүргүүлсэн.<br>Засгийн газрын хэрэг эрхлэх газраас 2025 оны 2 дугаар | 90 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | сарын 14-ны өдрийн ХЭГ/467 дугаар албан бичгээр ирүүлсэн Татварын хууль, тогтоомжуудыг боловсронгуй болгох хуулиудын төсөлд Газрын төлбөрийн тухай хууль, хуулийн үзэл баримтлалтай уялдуулан холбогдох санал өгч ажилласан. | |
| 3.7.2.2 | Хот, тосгон бусад суурин 1 га газрын суурь үнэлгээ болон зэрэглэл /бүс/-ийг шинэчлэн тогтоох | Үйл ажиллагаа | Засгийн газрын тогтоол | Засгийн газрын 2018 оны 182 дугаар тогтоол | **Эхний хагас жилд:**<br>Хот, тосгон бусад суурин газрын зах зээлийн үнэд суурилсан масс үнэлгээг газрын үнэлгээний цахим системээр хийж үр дүнг ажлын хэсэг болон холбогдох хуралд танилцуулсан байна.<br>**Жилийн эцэст:**<br>Хот, тосгон бусад суурин газрын 1 га газрын суурь үнэлгээг шинэчлэн боловсруулсан Засгийн газрын тогтоолын төслийг ДДЗХ-р хэлэлцүүлсэн байна. | Улсын хэмжээнд 21 аймаг, Нийслэл, Дүүрэг, 330 сумын хот, тосгон бусад суурины газрын үнэлгээний бүс, 1 га газрын суурь үнийг тодорхойлохдоо нийт 71948 зах зээлийн үнийн мэдээ цуглуулан боловсруулалт хийсэн. Газрын үнэлгээний системээр үнэлэхэд зах зээлийн үнийн мэдээнээс шалтгаалан газрын суурь үнэ өмнөх үнэлгээ буюу Засгийн газрын 2018 оны 182 дугаар тогтоолоор баталсан суурь үнэлгээнээс дунджаар 7-40 хувиар нэмэгдсэн үр дүн гарсан бөгөөд газрын суурь үнэлгээг шинэчлэн боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг болон 2025 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн даргын дэргэдэх зөвлөлийн хурлаар хэлэлцүүлсэн.<br>Газрын үнэлгээний цахим системийг ашиглан боловсруулан гаргасан хот, тосгон бусад суурины газрын үнэлгээний үр дүн (өсөлт) өөрчлөлт нь улс орны нийгэм, эдийн засаг, иргэн, хуулийн этгээдийн амьдрал, үйл ажиллагаанд хэрхэн нөлөөлөх талаар үр нөлөө болон үр өгөөжийн нарийвчилсан | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | судалгааг хийлгэхээр мэргэжлийн судалгааны байгууллага, мэргэжилтнүүдээс үнийн санал авч газрын даргад танилцуулсан. Мөн Засгийн газрын 2018 оны 182 дугаар тогтоолд өөрчлөлт оруулах Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулан холбогдох материалын хамт 2025 оны 05 дугаар сарын 21-ний өдрийн 1/1750 дугаартай албан бичгээр Засгийн газрын хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн. | |
| 3.7.2.3 | Газрын үнэлгээний тойрог, хөдөө аж ахуйн 1 га газрын суурь үнэлгээг шинэчлэн тогтоох | Үйл ажиллагаа | Засгийн газрын тогтоол | Засгийн газрын 2018 оны 182 дугаар тогтоол | **Эхний хагас жилд:**<br>Газрын үнэлгээний тойрог, хөдөө аж ахуйн 1 га газрын суурь үнэлгээг шинэчлэн боловсруулж үр дүнг ажлын хэсэг болон холбогдох хуралд танилцуулсан байна.<br>**Жилийн эцэст:**<br>Газрын үнэлгээний тойрог, хөдөө аж ахуйн 1 га газрын суурь үнэлгээг шинэчлэн боловсруулсан Засгийн газрын тогтоолын төслийг ДДЗХ-р хэлэлцүүлсэн байна. | Хөдөө аж ахуйн газрын суурь үнэлгээ болон газрын үнэлгээний тойрог шинэчлэн боловсруулан газрын суурь үнэлгээг шинэчлэн боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг болон 2025 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн даргын дэргэдэх зөвлөлийн хурлаар хэлэлцүүлсэн. Үр дүнгээр гарсан өөрчлөлт нь улс орны нийгэм, эдийн засаг, иргэн, хуулийн этгээдийн амьдрал, үйл ажиллагаанд хэрхэн нөлөөлөх талаар үр нөлөө болон үр өгөөжийн нарийвчилсан судалгааг хийлгэхээр мэргэжлийн судалгааны байгууллага, мэргэжилтнүүдээс үнийн санал авч газрын даргад танилцуулсан. | 80 |
| **3.1.4** | **Хууль тогтоомжийн дагуу төлбөр ногдуулах, хураамжийн нэхэмжлэл үүсгэх** | **Үйл ажиллагаа** | **Засгийн газрын тогтоол** | **Засгийн газрын 2018 оны 182 дугаар тогтоол** | **Газрын үнэлгээний тойрог, хөдөө аж ахуйн газрын 1 га газрын суурь үнэлгээг шинэчлэн тогтоосон байна.** | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 3.1.4.1 | Ашигт малтмал, газрын тосны газраас ашиглалтын тусгай зөвшөөрөл олгосон талбайн хэмжээгээр газар ашиглах эрхийг баталгаажуулан мэдээллийн санд бүртгэсэн нэгж талбарт газрын төлбөр тооцож, ногдуулалт үүсгэх | Үйл ажиллагаа | Тусгай зөвшөөрөл олгосон тоогоор | Газрын төлбөр, татварын системийг нэвтрүүлсэн. | **Эхний хагас жилд:**<br>Ашигт малтмал, газрын тосны газраас ашиглалтын тусгай зөвшөөрөл олгосон талбайн хэмжээгээр газар ашиглах эрхийг баталгаажуулан мэдээллийн санд бүртгэсэн газрын төлбөр тооцож, ногдуулалт үүсгэсэн байна.<br>**Жилийн эцэст:**<br>Ашигт малтмал, газрын тосны газраас ашиглалтын тусгай зөвшөөрөл олгосон талбайн хэмжээгээр газар ашиглах эрхийг баталгаажуулан мэдээллийн санд бүртгэсэн газрын төлбөр тооцож, ногдуулалт үүсгэсэн байна. | Ашигт малтмал, газрын тосны газраас улсын хэмжээнд ашиглалтын тусгай зөвшөөрөл олгосон Газрын кадастрын мэдээллийн цахим системд бүртгэлтэй 1,358 нэгж талбарт 50 тэрбум 761 сая төгрөгийн ногдуулалт үүсгэж Татварын удирдлагын нэгдсэн цахим системд илгээсэн байна.<br>Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 03 дугаар сарын 19-ний өдрийн 13 дугаар хуралдааны тэмдэглэлийн 1.4 дэх хэсэгт уул уурхай, ашигт малтмалын тусгай зөвшөөрөлтэй газрын эрхийг баталгаажуулах ажлыг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгуулж, 2025 оны 04 дүгээр сарын 16-ны өдрийн 1/1284 дугаар албан бичгээр 21 аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар, нийслэл, дүүргийн Газар зохион байгуулалтын албанд дээрх хууль, тогтоомж, шийдвэрийн хэрэгжилтийг хангаж уул уурхай, ашигт малтмалын тусгай зөвшөөрөлтэй газрын эрхийг Газрын удирдлагын нэгдсэн цахим системд бүртгэж баталгаажуулан, газрын төлбөрийн ногдуулалтыг үүсгэж ажиллах чиглэлийг хүргүүлсэн.<br>Мөн Ашигт малтмал, газрын тосны газраас ашиглалтын тусгай зөвшөөрөл олгосон талбайн хэмжээгээр газар ашиглах эрхийг баталгаажуулах, мэдээллийн | 90 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | санд бүртгэх, газрын төлбөр тооцож, ногдуулалт үүсгэх талаар 21 аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын холбогдох мэргэжилтнүүд, сумын дамлуудад цахим сургалт хийж мэргэжил, арга зүйгээр ханган ажиллаж байна. | |
| 3.1.4.2 | Газрын төлбөр, татвар, тэмдэгтийн хураамж, үйлчилгээний хураамжийг цахимаар төлөлт хийх бүх боломжуудын талаар иргэд, олон нийтэд сурталчлах | Үйл ажиллагаа | Олон нийтэд сурталчилсан ажлын тоо | Газрын төлбөр, татварын системийг нэвтрүүлсэн. | **Жилийн турш:**<br>Газрын төлбөр, татвар, тэмдэгтийн хураамж, үйлчилгээний хураамжийг цахимаар төлөх боломжуудыг иргэд, олон нийтэд сурталчилах ажлыг зохион байгуулсан байна. | Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын холбогдох мэргэжилтнүүд, сумын дамлуудад газрын төлбөр, татвар, тэмдэгтийн хураамж, үйлчилгээний хураамжийг цахимаар төлөх, иргэн хуулийн этгээдэд дэлгэрэнгүй мэдээлэл өгч ажиллаж талаар сургалт хийж мэргэжил арга зүйн зөвлөмжийг өгч ажилласан.<br>Мөн утсаар болон үйлчилгээ авахаар ирсэн иргэн, хуулийн этгээдэд газрын төлбөр, татвар, тэмдэгтийн хураамж, үйлчилгээний хураамжийг цахимаар төлөлт хийх бүх боломжуудын талаар зөвлөмж өгч, олон нийтэд сурталчлан таниулж байна. | 100 |
| 3.1.4.3 | Төлбөрийн даалгавар үүсгэн улсын тэмдэгтийн хураамж, хураамжийн ногдуулалтыг хийж Татварын удирдлагын нэгдсэн системд илгээх ажлыг зохион байгуулах | Үйл ажиллагаа | Эрх шилжүүлсэн, барьцаалсан, эзэмших, ашиглах эрх олгосон, хугацаа сунгасан нэгж талбарын тоогоор | Газрын төлбөр, татварын системийг нэвтрүүлсэн. | **Эхний хагас жилд:**<br>Газар эзэмших эрх шилжүүлсэн, барьцаалсан, эзэмших, ашиглах эрх олгосон, хугацаа сунгасан нэгж талбарын тоогоор улсын тэмдэгтийн хураамжийн төлбөрийн даалгавар үүсгэсэн байна.<br>**Жилийн эцэст:** | Улсын хэмжээнд газар эзэмших эрхийг бусдад шилжүүлэх, барьцаанд бүртгүүлэх, хугацаа сунгах зэрэг эрх зүйн харилцаанд орсон 2,340 нэгж талбарт Газрын төлбөр, татварын цахим системээс улсын тэмдэгтийн хураамжийн төлбөрийн даалгавар үүсгэж, 23 сая 532 мянган төгрөгийн ногдуулалтыг хийж Татварын | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Эрх шилжүүлсэн, барьцаалсан, эзэмших, ашиглах эрх олгосон, хугацаа сунгасан нэгж талбарын тоогоор улсын тэмдэгтийн хураамжийн төлбөрийн даалгавар үүсгэсэн байна. | удирдлагын нэгдсэн системд илгээх ажлыг зохион байгуулсан. | |
| 3.7.5 | **Газрын зөрчил, маргаантай холбоотой асуудлыг шийдвэрлэх, холбогдох арга хэмжээг зохион байгуулах** | **Үйл ажиллагаа** | **Шийдвэрлэсэн албан бичиг, өргөдлийн тоо** | **2024 онд иргэний болон захиргааны шүүх, Авлигатай тэмцэх газар, эрх бүхий байгууллагаас ирүүлсэн 218 албан бичиг, иргэний 63 өргөдлийг шийдвэрлэсэн.** | **Шүүх, Авлигатай тэмцэх газар болон эрх бүхий байгууллагаас шинжээчээр томилсон тогтоол, захирамжийн хэрэгжилтийг хангах, дүгнэлт гаргах, нотлох баримтыг хүргүүлсэн байна.** | | |
| 3.7.5.1 | Шүүх, Авлигатай тэмцэх газар болон эрх бүхий байгууллагаас шинжээчээр томилсон тогтоол, захирамжийн хэрэгжилтийг хангах, дүгнэлт гаргаж хүргүүлэх ажлыг зохион байгуулах | Үйл ажиллагаа | Шийдвэрлэсэн албан бичиг, өргөдлийн тоо, тушаалын биелэлт | 2024 онд 29 ажлын хэсэг байгуулж холбогдох шинжээчийн дүгнэлтийг хүргүүлсэн. | **Эхний хагас жилд:** Шүүх, Авлигатай тэмцэх газар болон эрх бүхий байгууллагаас шинжээчээр томилсон тогтоол, захирамжийн хэрэгжилтийг хангах ажиллаж шинжээчийн дүгнэлтийг хүргүүлсэн байна.<br>**Жилийн эцэст:** Шүүх, Авлигатай тэмцэх газар болон эрх бүхий байгууллагаас шинжээчээр томилсон тогтоол, захирамжийн хэрэгжилтийг хангах ажиллаж шинжээчийн дүгнэлтийг хүргүүлсэн байна | Дараах Шүүх, Авлигатай тэмцэх газар болон эрх бүхий байгууллагаас шинжээчээр томилсон тогтоол, захирамжийн хэрэгжилтийг хангах, дүгнэлт гаргаж хүргүүлэх ажлыг зохион байгуулан ажиллаж байна. Үүнд:<br>- Авлигатай тэмцэх газрын мөрдөн шалгах хэлтсийн ахлах мөрдөгч, ахлах комиссар Э.Мөнхцэнгэлийн 2024 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн тогтоолоор 23020007930001 дугаартай эрүүгийн хэрэгт.<br>- Авлигатай тэмцэх газрын мөрдөн шалгах хэлтсийн Д.Алтангэрэл мөрдөгч, комиссарын 2025 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн тогтоолоор эрүүгийн хэргийн 233700063 дугаартай хэрэгт шинжээчийн | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсэг;<br>- Увс аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн ерөнхий шүүгч Д.Алтанцэцэгийн 2025 оны 01 дүгээр сарын 21-ний өдрийн 124/Ш32025/0029 дугаар "Шинжээч томилон, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлэх" тухай шүүгчийн захирамж | |
| 3.7.5.2 | Шүүх, Авлигатай тэмцэх газар болон эрх бүхий байгууллага, иргэний хүсэлтийн дагуу нотлох баримтыг гаргаж холбогдох байгууллага, иргэнд хүргүүлэх | Үйл ажиллагаа | Албан тоот, өргөдөл хүсэлт | 2024 онд иргэний болон захиргааны шүүх, Авлигатай тэмцэх газар, эрх бүхий байгууллагаас ирүүлсэн 218 албан бичиг, иргэний 63 өргөдлийг шийдвэрлэсэн. | **Эхний хагас жилд:** Шүүх, Авлигатай тэмцэх газар болон эрх бүхий байгууллага, иргэн, хуулийн этгээдийн өргөдөл, гомдлын дагуу нотлох баримтыг хүргүүлсэн байна.<br>**Сүүлийн хагас жилд:** Шүүх, Авлигатай тэмцэх газар болон эрх бүхий байгууллага, иргэн, хуулийн этгээдийн өргөдөл, гомдлын дагуу нотлох баримтыг хүргүүлсэн байна. | Дараах Шүүх, Авлигатай тэмцэх газар болон эрх бүхий байгууллага, иргэний хүсэлтийн дагуу нотлох баримтыг гаргаж холбогдох байгууллага, иргэнд хүргүүлээд байна. Үүнд:<br>- Авлигатай тэмцэх газрын мөрдөн шалгах хэлтсийн албаны дарга ахлах комиссар Э.Оюунболдын 2025 оны 02 дугаар сарын 13-ны өдрийн албан бичигт;<br>- "Авалон лекс" хууль зүйн фермийн (хувийн хэргийн дугаар:9011324012) үйл ажиллагааны 2025 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн албан бичигт;<br>- Авлигатай тэмцэх газрын мөрдөн шалгах хэлтсийн 2025 оны 06/9066 дугаартай албан бичигт;<br>- Авлигатай тэмцэх газрын мөрдөн шалгах хэлтсийн 2025 оны 06/8805 дугаартай албан бичигт;<br>- Авлигатай тэмцэх газрын мөрдөн шалгах хэлтсийн 2025 оны 06/7488 дугаартай албан бичигт; | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | - Авлигатай тэмцэх газрын мөрдөн шалгах хэлтсийн 2025 оны 06/6477 дугаартай албан бичигт;<br>- Авлигатай тэмцэх газрын мөрдөн шалгах хэлтсийн 2025 оны 06/3766 дугаартай албан бичигт; | |

## ДӨРӨВ. ХУУЛИАР ОЛГОСОН НИЙТЛЭГ ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/ | Гүйцэтгэл -ийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 4.1 | Удирдлагаас болон хурлаас өгөгдсөн үүрэг даалгаврыг хэрэгжүүлэх, тайлагнах | Үйл ажиллагаа | Үүрэг даалгаврын тоо | Жил бүр хийгддэг. | Өгөгдсөн үүрэг даалгаврыг хэрэгжүүлж, тухай бүр тайлагнасан байна. | 2025 оны нэгдүгээр улирлын байдлаар удирдлагаас болон хурлаас өгөгдсөн дараах үүрэг даалгаврыг хэрэгжүүлж, "Эйбл" Байгууллагын дотоод удирдлагын цогц систем биелэлтийг дэлгэрэнгүй бичиж оруулсан байна.<br>- 2025 оны урсгал зардлаар хийж гүйцэтгэх ажилд Газрын биржийн үйл ажиллагаатай холбоотой санал боловсруулж, санхүүгийн тооцооллыг хийж СЭЗХ-т хүргүүлсэн.<br>- Газрын биржийн асуудал хариуцсан мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр, зохион байгуулалтын бүтэцтэй уялдуулан боловсруулж, албан тушаалын тодорхойлолтыг харьцуулан, албан тушаалын тодорхойлолт боловсруулах | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | мэдээлэл цуглуулах асуулгын хуудсыг гаргасан.<br>- Засгийн газрын хэрэг эрхлэх газрын 2025 оны 02 дугаар сарын 03-ны өдрийн дугаар Х/132 албан бичгээр ирүүлсэн хүсэлтийн дагуу Газар эзэмшүүлэх, ашиглуулах төсөл шалгаруулах журам"-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай тогтоолын төслийн боловсруулсан.<br>- "Улсын хэмжээнд газрын үнэлгээний бүс /тойрог, зэрэглэл/, суурь үнэлгээ, төлбөрийн хэмжээг шинэчлэн тогтоох" ажлын ажлын даалгаврыг боловсруулж, зардлын тооцоог гаргасан.<br>- "Иргэдийн итгэлийг хүлээсэн төрийн үйлчилгээний жил"-ийн хүрээнд салбарын хэмжээнд хэрэгжүүлэх үйл ажиллагааны нэгдсэн төлөвлөгөөнд санал өгч, биелэлтийг гаргаж байна.<br>- Газар ашиглалтын өнөөгийн байдал, цаашид авах арга хэмжээний санал боловсруулж, танилцуулга бэлтгэсэн.<br>- "Ногоон ззэлээр гэр хорооллыг багасгах, орон сууцжуулах боломж" сэдвийн хүрээнд судалгаа хийж, танилцуулга бэлтгэсэн.<br>- Хангайн бүсийн зөвлөгөөний үеэр гарсан саналын дагуу Газрын тухай хуульд өөрчлөлт оруулахыг Монгол | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | улсын Ерөнхий сайдаас өгөгдсөн үүрэг даалгаврын дагуу газрын тухай хуульд оруулах саналыг боловсруулж, тухайн нэмэлт, өөрчлөлтийг оруулах хэрэгцээ, шаардлагын танилцуулга бэлтгэсэн.<br>- Удирдах ажилтны өргөтгөсөн шуурхай зөвлөгөөнд газрын биржийн талаар өгөх үүрэг, даалгаврын саналыг гаргаж, нэгтгэсэн. | |
| 4.2 | Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд ажиллаж, тайланг тушаалд заасан хугацаанд холбогдох мэргэжилтэнд хүргүүлэх | Үйл ажиллагаа | Тушаалд заасан хугацаа | Жил бүр хийгддэг. | Ажлын хэсэгт ажиллаж, хэрэгжилтийг тухай бүр тайлагнасан байна. | Дараах ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орж ажиллан, заасан хугацаанд холбогдох үүрэг даалгаврыг биелүүлж, тайлагнаж байна. Үүнд:<br>- Газрын нэгдмэл сангийн 2024 оны улсын нэгдсэн тайланг нэгтгэн гаргах ажлын хэсгийг Газрын даргын 2025 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн А/01 тоот тушаалаар ажлын хэсэгт;<br>- Газрын даргын 2025 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн А/105 дугаар тушаалаар Газрын харилцааны ажилтны өдрийг тохиолдуулан тус салбарын шилжин явах цомын төлөөх спортын тэмцээнийг зохион байгуулах үүрэг бүхий ажлын хэсэгт;<br>- Монгол улсын Сангийн сайдын 2024 оны 09 дүгээр сарын 02-ны өдрийн 152 дугаар тушаалаар батлагдсан Татварын зорилгоор хөрөнгийн үнэлгээ хийх журам, загварын аргачлалыг боловсруулах ажлын хэсэг. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | - Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газрын даргын 2024 оны А/287 дугаар тушаалаар байгуулагдсан Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 182 дугаар тогтоолоор баталсан газрын суурь үнэлгээг шинэчлэн боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэгт.<br>- Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газрын даргын 2025 оны А/58 дугаар тушаалаар байгуулагдсан үнэлгээний хороо;<br>- ГЗБГЗЗЕГ-ын даргын 2025 оны А/145 дугаар тушаалаар байгуулагдсан Газрын тухай хуулийн төслийн үзэл баримтлалын төсөл, хуулийн төслийг боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг. | |
| 4.3 | Тогтоол шийдвэрийн биелэлт гаргах | Үйл ажиллагаа | Тогтоол, шийдвэрийн тоо | Жил бүр хийгддэг. | Холбогдогдох тогтоол шийдвэрийн биелэлтийг цаг хугацаанд нь тайлагнасан байна. | Дараах тогтоол шийдвэрийн биелэлт цаг тухай бүрт нь гаргаж байна. Үүнд:<br>- Газрын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.2 дахь заалт болон Монгол улсын Засгийн газрын 2024 оны 187 дугаар тогтоолоор "Газар эзэмшүүлэх, ашиглуулах төсөл сонгон шалгаруулах журам"-д нэмэлт өөрчлөлт орсонтой холбогдуулан малчдын хоршоонд төсөл сонгон шалгаруулалтаар газар олгож буй асуудлаар биелэлт гаргаж танилцуулж байна.<br>- Монгол улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн газар, үл хөдлөх | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хөрөнгийн нэгдсэн бүртгэл, үнэлгээ, төлбөр, татвар, биржийн системийг хөгжүүлж, үйл ажиллагааг нь эхлүүлэх ажлын биелэлтийг гаргаж, танилцуулсан.<br>- Монгол улсын их хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигт туссан арга хэмжээний биелэлтыг гаргасан.<br>- Монгол улсын Сангийн сайдын баталсан 2025 оны 2 дугаар сарын 11-ний өдрийн СХШХ/06 дугаар нэгдсэн удирдамжийн хүрээнд Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар, Нийслэл, дүүргийн газар зохион байгуулалтын алба, аймгуудын Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газруудын 2023, 2024 оны газрын харилцаа, газрын төлбөр ногдуулалттай холбоотой хууль эрх зүйн актгай холбоотой хяналт, шалгалтын үр дүн, дүгнэлтэд тайлбар гаргасан. | |
| 4.4 | Хугацаатай албан бичиг, өргөдөл гомдол шийдвэрлэх, хяналт тавьж ажиллах | Үйл ажиллагаа | Шийдвэрлэсэн албан бичиг, өргөдөл, гомдлын тоо | Жил бүр хийгддэг. | Нэгжид ирсэн хугацаатай албан бичиг, өргөдөл гомдлыг заасан хугацаанд нь шийдвэрлэсэн байна. | 2025 оны хоёрдугаар улирлын байдлаар тус хэлтэст нийт 84 албан бичиг хуваарилагдан ирснээс хариутай 34, хариугүй 50 албан бичиг байна. Хариутай 34 бичгийн цаг тухай бүрт нь шийдвэрлэсэн.<br>Мөн иргэн, аж ахуйн нэгж байгууллагаас нийт 17 өргөдөл, хүсэлт ирсний 17-ыг нь шийдвэрлэсэн. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Тус хэлтсээс 48 албан бичгийг боловсруулан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудад хүргүүлсэн байна. | |
| 4.5 | Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу архивын баримт бүрдүүлэх, хавтаслах, байгууллагын архивт хүлээлгэн өгөх | Үйл ажиллагаа | Архивт хүлээлгэн өгсөн баримтын тоо | Жил бүр хийгддэг. | Нэгжийн урьд онд хийсэн ажлын баримт бичгийг тайлант оны эхний улиралд багтаан байгууллагын архивт хүлээлгэн өгөх ажлыг зохион байгуулсан байна. | Салбарын архивийн хэлтэст дараах материалыг хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу архивын баримт бүрдүүлж, хавтаслан хүлээлгэн өгсөн. Үүнд:<br>- Тус хэлтсийн хэмжээнд 2024 онд ирүүлсэн албан бичиг, өргөдөл, гомдлын цаасан хувь;<br>- 2024 онд зохион байгуулагдсан "Газрын төлбөр үнэлгээ болон Газрын төлбөр татварын цахим системийн хөгжүүлэлт хийх", "Газрын биржийн цахим системийн нэмэлт хөгжүүлэлт (газрын дуудлага худалдаа, төсөл сонгон шалгаруулалт зохион байгуулах үйл ажиллагааг боловсронгуй болгох)" зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийн баримт, бичиг. | 100 |

## ТАВ. МЭДЛЭГ ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/ | Гүйцэтгэл -ийн хувь |
|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | |
| "5. ТӨРИЙН АЛБАНЫ ТУХАЙ ХУУЛЬ, САЛБАРЫН ХУУЛЬ, ДАГАЛДАН ГАРСАН ХУУЛЬ ТОГТООМЖИД ЗААСАН МЭДЛЭГ ЧАДВАРЫГ ЭЗЭМШИХ, ТАСРАЛТГҮЙ ХӨГЖҮҮЛЭХ" ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД: | | | | | |
| 5.1 | Хууль эрх зүйн чиглэлээр сургалтад хамрагдах | Сургалт эхэлсэн байна | Хууль, эрх зүйн чиглэлээр их дээд сургуулийн бакалаврын түвшинд элсэн орж сургалт эхлүүлсэн байна. | Монгол улсын Эрдмийн их сургуулийн хууль зүйн тэнхимийн эрх зүйн бакалаврын оройн ангид элсэн суралцаж байна. | 100 |

__oOo__